

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 01.080.10; 03.240

Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага	MNS 5283:2022
General requirements for address sign of street, road, square, immovable properties, organizations and companies	MNS 5283:2014-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн С/41 дүгээр тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэ стандартаар гудамж, зам, талбай, түүх соёлын дурсгалт газар, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэг, хаягийн зурган самбар болон төрийн байгууллагын хаягийн самбарыг нэг загвараар үйлдвэрлэх, байрлуулах, нэгдсэн загвар, аргачлалыг тодорхойлно.

Энэ стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд суурьшсан хэсгийн гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагыг баталгаажсан хаягаар тэмдэгжүүлэхэд мөрдөнө.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан баримт бичгийг хэрэглэнэ. Хугацаа заасан эшлэлийн хувьд дурдсан хэвлэл, харин хугацаа заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

MNS ISO 3098-2:2003, *Техникийн бичиг баримт. Шрифт. 2-р хэсэг. Латин цагаан толгой болон бусад тэмдэг.*

MNS ISO 3098-6:2003, *Техникийн бичиг баримт. Шрифт. 6-р хэсэг. Кирилл цагаан толгой.*

MNS 5217:2012, *Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг.*

MNS 4333:1996, *Монгол бичгийн цагаан толгой.*

MNS 6275:2011, *Нэгдсэн хаягжуулалт, Хаягийн бичвэрт тавих шаардлага. А, В хавсралт.*

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

хаяг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, батлагдсан газар зүйн нэр бүхий газар нутаг, хот, суурин газар дах гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын байршлыг тодорхойлсон, аж ахуйн нэгж, байгууллагын өрөөний хаягийн үсэг, тооны илэрхийлэл;

3.2

хаягжуулах

гудамж, зам, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулах, үл хөдлөх эд хөрөнгөд дугаар олгох, хаягийн мэдээллийн санд бүртгэх, хөтлөх, өөрчлөх, хүчингүй болгох, хаягийн зураг зохиох, хаягийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэх, байршуулах цогц үйл ажиллагаа;

3.3

хаягийн зурган самбар

аймаг, сум, суурин, хороолол, хотхон, талбай, түүх соёлын дурсгалт газар болон төлөвлөлтгүй суурьшсан хэсгийн хил зааг дээр нийтэд ойлгомжтой байдлаар байрлуулсан хаягийн байршил харуулсан хаягийн зураг бүхий самбар;

3.4

хаягийн тэмдэг

стандартын дагуу үйлдвэрлэн, хашаа байшингийн хананд байрлуулах, гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн баталгаажсан нэр бүхий тэмдэг;

3.5

хаягийн самбар

стандартын дагуу үйлдвэрлэн, байшингийн хананд суулгах аж ахуйн нэгж, байгууллагын баталгаажсан нэр бүхий самбар.

4 Хаягийн самбар, хаягийн тэмдгийн төрөл

4.1. Энэ стандартад аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн самбарыг дараах төрлөөр ангилна. Үүнд:

4.1.1 Төрийн байгууллагын хаягийн самбар;

4.1.2 Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн самбар;

4.1.3 Объектын байрлалыг /чиглэл/ заасан самбар;

4.1.4 Түүх соёлын дурсгалт газрын самбар.

4.2 Энэ стандартад хаягийн тэмдгийг дараах төрлөөр ангилна. Үүнд:

4.2.1 Гудамжны хаягийн тэмдэг;

4.2.2 Үл хөдлөх эд хөрөнгийн /Байшин, барилга, хашаа, орцны / хаягийн тэмдэг;

4.2.3 Байгууллагын нэрийн тэмдэг;

4.2.5 Байшин доторх хаалганы тэмдэг.

5 Ерөнхий шаардлага

5.1 Хаягийн зурган самбарт тавих шаардлага

5.1.1 Засаг захиргааны нэгж болон хороолол, хотхон, талбай, төлөвлөлтгүй суурьшсан хэсэг нь хаягийн зурган самбартай байна

5.1.2 Хаягийн зурган самбарын загвар, хэлбэр хэмжээ, өнгийг энэ стандартын С хавсралтын С.1, С.2-р хүснэгтэд заасны дагуу мөрдөнө.

5.1.3 Засаг захиргааны нэгжийн болон хороолол, хотхоны хаягийн зурган самбар дээр засаг захиргааны нэгж болон хороолол, хотхоны батлагдсан нэрийг монгол

бичгээр бичнэ.

5.1.4 Засаг захиргааны нэгжийн болон хороолол, түүх соёлын дурсгалт газар, хотхоны батлагдсан монгол нэрийг хаягийн зурган самбар дээр бичнэ. Орчуулж бичихийг хориглоно.

5.1.5 Замын зурвас газарт (замаас 50 м хүртэлх зайд) суурилуулах замын, гудамжны, талбайн хаягийн тэмдгийг “MNS 4597:2014, Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” стандартын тэмдгийг “MNS 4596:2014, Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” стандартын дагуу холбогдох мэргэжлийн байгууллагаар байрлуулна.

5.2 Хаягийн тэмдэгт тавих шаардлага

5.2.1 Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө хаягийн тэмдэгтэй байна.

5.2.2 Гудамж, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдгийн загвар, хэлбэр хэмжээ, өнгийг А хавсралтын А.1, А.2-р хүснэгтэд заасны дагуу мөрдөнө. Өнгөний код: Цагаан өнгө “RGB-255,255,255, Хөх өнгө RGB-0,79,158, хар өнгө “RGB-0,0,0”, ногоон өнгө “RGB-31; 138; 61”.

5.2.3 Гудамж, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн батлагдсан монгол нэрийг хаягийн тэмдэг дээр бичнэ. Орчуулж бичихийг хориглоно.

5.2.4 Гудамж, талбайн нэрийг түүхэн хүний нэрээр нэрлэсэн тохиолдолд нэрийг нь товчлон бичихгүй, овгийг товчилж болох бөгөөд нэрд орсон үг бүрийг том үсгээр эхлүүлэн бичнэ. Нэрд мэргэжил, мэргэжлийн зэрэг, цолыг оруулж болно. А хавсралтын А.1-р хүснэгт 2-р зурагт заасан байдлаар хийнэ.

5.2.5 Гудамжны нэрийн тэмдэг нь бие даасан шонд суурилуулах бөгөөд 2-оос дээш нэрийн тэмдэг байршуулах бол зориулалтын холбоосыг ашиглана.

5.3 Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн самбарт тавих шаардлага

5.3.1 Аж ахуйн нэгж, байгууллага үйлчилгээгээ иргэдэд ойлгомжтой, чирэгдэлгүй, шуурхай байдлаар тав тухтай орчинд үзүүлэх нөхцөл боломжийг анхаарч үйл ажиллагаа явуулж байгаа барилга болон ажлын байрны гадна талд байгууллагын нэрийн тэмдгийг В хавсралтын В.6-р зурагт заасны дагуу байршуулна.

5.3.2 Төрийн байгууллагын нэрийн самбар нь нэрийн бичвэр, соёмбо, байгууллагын лого, бэлгэ тэмдэг зэргийг агуулна. байгууллагын бүтэн нэрийн бичвэр нь Монгол хэл, англи хэл, монгол бичгээр бичигдэнэ.

5.3.3 Төрийн байгууллагуудыг дараах байдлаар ангилна.

- а). Төрийн гүйцэтгэх дээд байгууллага, Яам түүний харьяа агентлаг, газар;
- б). Аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд;
- в). Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа байгууллага.

5.3.4 Төрийн байгууллагуудын нэрийн тэмдгийн дэвсгэр өнгө нь байгууллагын ангиллаас хамааран алтан шар, хөх цэнхэр, мөнгөлөг өнгөтэй байх ба А хавсралтын А.3-р хүснэгт 1,2,3-р зурагт заасан байдлаар хэрэглэнэ.

5.3.5 Олон аж ахуйн нэгж, байгууллага байрлаж буй байшингийн гадна, дотор талд байрлах хаягийн нэгдсэн самбарт хэмжээ заахгүй бөгөөд архитектур талаасаа тухайн байшин, барилга, орчны дизайнтай нийцсэн, загвар, өнгө үзэмжтэй, гадна эсвэл дотор гэрэлтүүлэгтэй, аль нэг байгууллага солигдох, мэдээлэл нь шинэчлэгдэх үед хялбар өөрчилж болох шийдэлтэй байна.

5.3.6 Олон аж ахуйн нэгж, байгууллага байрлаж буй байшингийн гадна талд эсвэл нэгдүгээр давхарт орох хаалганы орчим ханан дээр тэдгээрийн хаяг бүхий мэдээллийн самбарыг байрлуулна.

5.3.7 Хаягийн нэгдсэн мэдээллийн самбарт барилгын давхар бүрийг доороос нь дээш нь дараалуулан бичиж тухайн давхарт байрлах аж ахуйн нэгж байгууллагын нэр, логог бичнэ.

5.3.8 Хаягийн мэдээллийн самбарт давхар бүрийг доороос нь дээш нь дараалуулан бичиж аж ахуйн нэгжийн лого, нэр, хаалганы дугаарыг В хавсралтын В.1, В.2-р зурагт заасны дагуу байршуулна.

5.3.9 Байшингийн дотор талд давхар бүрт ханан дээр аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн самбар байрлана. Самбарт өрөөний дугаарын дарааллаар аж ахуйн нэгжийн нэрийг дээрээс нь доош нь бичих бөгөөд түүнд тухайн нэгжийн лого, нэр, өрөөний дугаар холбоо барих утасны дугаар байна.

5.4 Аж ахуйн нэгж, байгууллагын дотор хаалганы хаягийн тэмдэгт тавих шаардлага

5.4.1 Байшингийн доторх хаалганы хаягийн тэмдэг В хавсралтын В.3-р зурагт заасан хэмжээтэй байна.

5.4.2 Хаалганы хаягийн тэмдэг дээр албан хаагчийн нэр, байгууллага, нэгжийн нэрийг бичнэ.

5.4.3 Албан хаагчийн нэрийг брайл үсгээр болон монгол бичгээр В хавсралтын В.3-р зурагт үзүүлсэн байрлалд бичнэ.

5.4.4 Хаалганы хаягийн тэмдэг нь хаалга нээгдэх талд, хаалган дээр шалнаас дээш 1.60 м зайтай В хавсралтын В.4-р зурагт заасны дагуу байрлуулна.

5.5 Объектын байрлал заасан хаягийн тэмдэгт тавих шаардлага

5.5.1 Хаягийн тэмдгийн загвар, хэлбэр хэмжээ, өнгийг энэ стандартын С хавсралтын С.2-р хүснэгтийн С.1, С.2, С.3 -р зурагт заасны дагуу мөрдөнө.

5.5.2 Хаягийн тэмдгийн материал нь (30-50) мм-ийн зузаантай, байгалийн үзэгдэлд тэсвэрлэхүйц, зэвэрдэггүй металл байх ба эсвэл хамгаалалтын гадаргуутай байна.

5.5.3 Хаягийн тэмдгийн дэвсгэр өнгө нь байгалийн аливаа үзэгдэлд хуурч гандахгүйгээс гадна шөнийн цагт саадгүй харагдах, тээврийн хэрэгслийн болон бусад төрлийн гэрлийн тусгалаар гэрэлтдэг материалаар хийнэ.

5.5.4 Хаягийн тэмдгийн тулгуур суурийг барилгын зургийн инженерийн зураг төслөөр хийж, хянаж шалгасан, батлагдсан орц, нормын дагуу хийж, байгалийн

аливаа үзэгдэлд тэсвэртэй, мал, амьтан шөргөөхөд унахгүйгээр газарт бат бөх суурилуулсан байна.

5.5.5 Гудамж, зам, өргөн чөлөөнд байрлуулсан хаягийн тэмдгийн 5000 мм-ийн радиуст багтах орчинд төрөл бүрийн рекламн самбар, эд зүйлс байрлуулахыг хориглоно.

5.5.6 Автозамын уулзвар дээр байрлуулах С хавсралтын С.2-р хүснэгтийн С.1, С.2-р зураг дахь объектын байрлалыг заасан тэмдэгт “Авто замын сүлжээний зураг”-т заасан батлагдсан зайн хэмжээг бичнэ.

5.5.7 Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэмд зааснаар чигийн урьдчилсан заалт 5.33.а-5.36 тэмдэг нь тууш замд байрласан бол ногоон, суурин газрын гаднах бусад замд байрласан бол цэнхэр, суурин газарт байрласан бол цагаан өнгийн дэвсгэртэй байна. (Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм 5.6). “MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” болон “MNS 4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” стандартуудыг мөрдөнө.

6 Хаягийн бичвэрт тавигдах шаардлага

6.1 Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн бичвэрт монгол хэлний зөв бичих дүрэм, монгол бичгийн зөв бичих дүрмийг баримтлан бичнэ.

6.2 Гудамж, зам, талбай хаягийн самбар, хаягийн тэмдгийн монгол бичгийн үсгийг CMs Ulaanbaatar Regular фонт, кирилл үсгийг Roboto Condensed Bold фонтоор бичнэ. А хавсралтын А.1-р хүснэгт, А.3-р хүснэгтэд үзүүлэв.

6.3 Үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдгийн монгол бичгийн үсгийг CMs Ulaanbaatar Regular фонт, кирилл үсгийг Roboto Condensed Bold фонтоор бичнэ. А хавсралтын А.1-р хүснэгт, А.2-р хүснэгт, В.1-р зурагт үзүүлэв.

6.4 Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдгийн монгол бичгийн үсгийг CMs Ulaanbaatar Regular фонт, кирилл үсгийг Roboto Condensed Bold фонтоор бичнэ. В хавсралтын, В.1-р зурагт үзүүлэв.

6.5 Төрийн байгууллагын хаягийн бичвэрийг кирилл, монгол бичиг, англи хэлээр хослуулан бичнэ. Монгол бичгийн үсгийн фонт нь CMs Ulaanbaatar Regular, 118 pt, 141.6 pt хэмжээтэй. Кирилл бичвэрийн өндөр ихдээ 30 мм, Roboto Condensed Bold, 118 pt, 141.6 pt хэмжээтэй байна.

6.6 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын хаягийн бичвэрийг кирилл, монгол бичгээр хослуулан бичнэ. Шаардлагатай тохиолдолд кирилл, монгол бичгээс гадна англи хэлээр хослуулан бичиж болно.

6.7 Олон улсын франчайзын бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд тухайн гэрээнд заасны дагуу өөрийн хаягаа хэрэглэж болно.

6.8 Хаягийн тэмдгийн бичвэрийг “MNS 5217, Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг” стандартын А хавсралтын А.9, А.10, А.11, А.12-р зурагт заасны дагуу бичнэ.

6.9 Үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэг дээр шуудангийн нэгдсэн кодыг А

MNS 5283:2022

хавсралтын А.2-р хүснэгтийн 1-р зурагт үзүүлсний адил тэмдгийн доод хэсэгт бичнэ.

6.10 Нэрийн тэмдэг, мэдээллийн самбар, хаягийн самбарт Сүлд, Соёмбо, Хангарди, байгууллагын логог дүрслэхдээ тэдгээрийн нэгж хэмжээс, тэг харьцааг баримтална.

6.11 Гадна хаяг болон нэрийн тэмдгийн бичвэрийг Монгол хэл /кирилл/, Англи хэлээр үг, үсгийн алдаагүй бичих бөгөөд самбарын зүүн талд Монгол бичгээр бичнэ.

6.12 Монгол бичгийн бичвэрийн эхний мөр самбарын зах хоорондын зай 6 см байна. Бичвэрийн эхний мөрийг мөр тэтгэж бичих ба үгийн титэм, шилбэ, гэдэс, нум, орхиц, сүүл зэрэг зурлага нь өмнөх болон дараах мөрний үг, үсэгт тулахааргүй бичигдсэн байна.

6.13 Төрийн байгууллагын нэрийн англи бичвэрийн өндөр кирилл бичвэрийн 2/1 буюу 15мм, Roboto Condensed Bold, 60 pt, 72 pt хэмжээтэй байна.

6.14 Байгууллагын нэрийн тэмдэгтийн тоо, хэмжээнээс шалтгаалан нэрийн бичвэрийн самбарын хэмжээний 70 см-ээс өндөргүй, өргөн нь 120 см байх ба нэрийн бичвэрийн үсгийн өндөр, үг, үсэг, лого, бэлэг тэмдгийн хоорондын зай, хэмжээг өөрчлөхгүй.

6.15 Төрийн байгууллагын нэрийн тэмдэгт соёмбо байна. А хавсралтын А.3-р хүснэгтэд үзүүлэв.

6.16 Дээд газар, яамны нэрийн тэмдгийн бичвэр самбарын хэмжээг А хавсралтын А.3-р хүснэгт 1-р зурагт үзүүлэв.

6.17 Аймаг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар тэдгээрийн харьяа байгууллагын нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээг А хавсралтын А.3-р хүснэгт 2-р зурагт үзүүлэв.

6.18 Сум дүүргийн Засаг даргын тамгын газар, хэлтэс, харьяа байгууллагын нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээг А хавсралтын А.3-р хүснэгт 3-р зурагт үзүүлэв.

6.19 Хүрээ нь захаасаа 1 см зайд 0,5 см өргөн хар өнгөтэй байна. А хавсралтын А.3-р хүснэгтийн 1,2,3-р зурагт үзүүлэв.

6.20 Монгол (кирилл) бичвэрийг голлуулж дээд дунд хэсэгт Соёмбыг (16×16) см, байгууллагын бэлгэ тэмдэг, логог (13×13) см хэмжээтэй байрлуулна.

6.21 Хаягийг шөнийн цагаар харагдахуйц гэрэлтүүлэгтэй байна.

6.22 Монгол бичгийн бичвэрийн мөр хоорондын зай 6 см байна.

6.23 Хаягийн тэмдгийн жишээ загварт бичвэр нь самбарын дээд, доод, баруун, зүүн захаас алслах зай хэмжээг үсгийн хэмжээнээс хамаарч (30-60) мм байна.

7 Хаягийн самбар, тэмдгийн материалын шаардлага

7.1 Хаягийн самбар, тэмдгийн материал, дэвсгэр өнгө, бичвэр нь аливаа байгалийн үзэгдэлд тэсвэртэй, хуурч гандахгүй, зэвэрдэггүй өнгөт ган төмөр байх бөгөөд В хавсралтын В.5-р зурагт үзүүлсний адил хамгаалалтын гадаргуутай байна.

7.2 Хаягийн тэмдгийн материал нь (0,8-1) мм-ийн зузаантай, гадна орчны цаг агаарын нөхцөлд тэсвэртэй, зэвэрдэггүй металл байх ба хамгаалалтын гадаргуутай, байгалийн аливаа үзэгдэлд элэгдэж, гандахгүйгээс гадна үзэгдэх орчин хязгаарлагдсан нөхцөлд тод харагдахуйц зохиомол гэрэлтүүлэгтэй байна.

8 Хаягийн тэмдэг байрлуулах

8.1 Төрийн байгууллагын нэрийн тэмдгийг барилга байгууламжийн нүүрэн талд, нийтэд харагдахуйц байрлуулах ба орох, гарах хаалганы орчимд байрлуулна.

8.2 Нэг барилга байгууламжид хэд хэдэн байгууллага, аж ахуйн нэгж байрлан үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд байгууллагын нэрийг барилга байгууламжийн гадна болон дотор талд мэдээллийн самбарт байрлуулах бөгөөд байгууллагын нэрийн тэмдгийг үйл ажиллагаа явуулж буй давхарт, зөвхөн өрөөнд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хаалганы гадна орох талын баруун гар талд байрлуулна.

8.3 Төрийн байгууллагын нэрийн тэмдэг байрлуулах жишиг загварыг В хавсралтын В.6, В.7-р зурагт үзүүлэв.

8.4 Нэрийн тэмдгийн самбарыг байрлуулах, суурилуулахдаа орчны аюулгүй байдлыг хангана.

8.5 Нэрийн тэмдгийг аюулгүй байдлыг хангаж, аливаа гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр унахгүйгээр бат бэх суурилуулна.

8.6 Нэрийн тэмдгийг зохих гадаргууд В хавсралтын В.8-р зурагт үзүүлснээр тогтооно.

8.7 Барилгажсан орчны гудамжны тэмдгийг “MNS 4596, Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм”-ийн А хавсралтын 5.35-д заасны дагуу хийж байрлуулна.

8.8 А хавсралтын 2-р хүснэгтийн 1-т заасан барилга, байшингийн гадна тавих дугаарын тэмдгийг тухайн байшин, барилгын зорчигч их байдаг талын 2 хананд, 2 ба 3 дугаар давхрын хооронд, ил харагдахаар В хавсралтын В.9-р зурагт үзүүлснээр байрлуулна.

8.9 Мөн барилгын өндрийн ангиллаас хамааруулан барилгын гадна хаягийн дугаарыг Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан зааврын дагуу нэмэлтээр байрлуулж болно.

8.10 А хавсралтын 2-р хүснэгтийн 2-т заасан орцны дугаарын тэмдгийг тухайн орцны хаалганы дээд хэсэгт тогтоох бөгөөд тэмдгийн баруун үзүүрт тухайн орцонд байгаа байрнуудын хаалганы дугаарыг заавал бичсэн байна. Жишээ: Тухайн барилгын 1-р орцонд 1-18 тоот хаалганууд хамаардаг байна.

8.11 А хавсралтын А.1-р хүснэгтийн 3-д заасан гэр хорооллын гудамжны тэмдгийг гудамжны эхлэл ба төгсгөлд хашааны дээд хэсэгт ирмэгүүдээс тус бүр 200 мм-ийн зайд тогтооно.

MNS 5283:2022

8.12 А хавсралтын А.1-р хүснэгтийн 4-д заасан хашааны дугаарын тэмдгийг хаалганы баруун гар талын хашааны дээд хэсэгт ирмэгүүдээс тус бүр 100 мм-ийн зайд тогтооно.

8.13 С хавсралтын С.1-р хүснэгтийн С.1, С.2-т заасан “Хаягийн зурган самбар”-ыг “MNS 4597, Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцүүлэн авто замын хөдөлгөөнд саад болохгүйгээр, хороолол, хотхоны орох хэсэгт байрлуулна.

9 Хаягийн тэмдэг, самбарын шошго, тээвэрлэлтэд тавих шаардлага

9.1 Хаягийн тэмдэг, хаягийн зурган самбарын их биен дээр буюу эсвэл залгаж бэхэлсэн тусгай шошго дээр дараах өгөгдөхүүнүүдийг бичсэн байна. Үүнд:

- а). үйлдвэрлэгчийн барааны тэмдэг;
- б). үйлдвэрлэсэн огноо;
- с). энэ стандарт болон техникийн нөхцөлийн тэмдэглэгээ.

9.2 Дээр дурдсан шошго бүхий хаягийн тэмдэг болон хаягийн зурган самбарыг механик гэмтлээс тусгаарлан модон буюу фанеран хайрцагт савлана.

9.3 Самбарыг тээвэрлэхдээ хооронд нь зөөлөвч, жийрэг хийн хавсарч, нугалж гэмтээхгүйгээр тээвэрлэнэ.

10 Үйлдвэрлэгчийн баталгаа

Үйлдвэрлэгч нь хаягийн тэмдэг болон хаягийн зурган самбарын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын нөхцөлийг хангаж, энэ стандартын шаардлагад нийцсэн баталгааг гаргана.

11 Стандартын хэрэгжилт

Хаягийн зургийн самбар, хаягийн самбар, хаягийн тэмдэг, тэмдэглэгээг энэ стандартад нийцүүлэн шинэчлэн байршуулна.

ТӨГСӨВ.

А хавсралт (норматив)

Хаягийн тэмдэг

А.1-р хүснэгт – Хаягийн тэмдгийн жишээ загвар

Хэмжээ мм-ээр

1 Өргөн чөлөө, гудамжны хаягийн тэмдэг Түлхүүр үг: 11 - Өргөн чөлөө, гудамжны дугаар Энхтайваны өргөн чөлөө - Өргөн чөлөө, гудамжны нэр  - Энхтайваны өргөн чөлөө - Enkhtaivanii – Энхтайваны	 Cms Ulaanbaatar Regular хэмжээ 250pt Roboto Condensed Bold хэмжээ 400pt хэмжээ 200pt хэмжээ 50.00 mm 350 mm Нийт урт нь гудамжны нэрээс хамаарна өнгөний код R-0, G-79, B-158
2 Гудамжны хаягийн тэмдгийн хэмжээ Гудамжинд байрлуулах хаягийн тэмдгийн хэмжээ 200-300 см өндөртэй, 10см диаметртэй металл баганад 60*80 хэмжээтэй газар ухаж цемент цутгаж байрлуулна. Гудамжинд байрлуулах хаягийн тэмдгийн хэмжээ	 Cms Ulaanbaatar Regular хэмжээ 250pt Roboto Condensed Bold хэмжээ 350pt хэмжээ 200pt 180 mm 300.00 mm 1200 mm өнгөний код R-0, G-79, B-158  өнгөний код R-0, G-79, B-158 Roboto Condensed Bold хэмжээ 300pt хэмжээ 150pt 180.0 mm 300 mm 1000 mm  Ашигласан Фонт нь Arial Narrow Bold хэмжээ 300pt хэмжээ 200pt 260 mm 1400 mm өнгөний код R-0, G-79, B-158

3 Гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг

Түлхүүр үг:

Алтайн -Гудамжны нэр, дугаар

1-20 - Тухайн гудамжинд байгаа хашааны дугаарууд




- Алтайн



4 Гэр хорооллын хашааны тоот

Түлхүүр үг:

123 – Хашааны дугаар




А.2-р хүснэгт – Хаягийн тэмдгийн жишээ загвар

Хэмжээ мм-ээр

1 Барилга, байшингийн хаягийн тэмдэг Түлхүүр үг: 101 - Байшингийн дугаар Их тойруу - Гудамжны нэр 15170-0005 Шуудангийн нэгдсэн код - Их тойруу Ikh toiruu- их тойруу	
2 Байрны орцны хаягийн тэмдэг Түлхүүр үг: 1 - Орцны дугаар 1-18 - Тухайн орцонд байгаа тоот хаалганы дугаарууд - орц	

А.3-р хүснэгт Байгууллагын нэрийн тэмдгийн жишээ загвар

Хэмжээ мм-ээр


№	Байгууллагын ангилал	Нэрийн тэмдгийн өнгө	Өнгөний код
1	Дээд газар, Яам түүний харьяа агентлаг, газар		HTML /CSS/ Алтан шар, Metallicgold/ Hex Code #RRGGBB /#D4AF37/ Decimal Code R,G,B /212,175,55/
2	Аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд		HTML /CSS/ Хөх цэнхэр, blue Hex Code #RRGGBB /#0000FF/Decimal Code R,G,B/ 0,0,255/
3	Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа байгууллага		HTML /CSS/ Мөнгөлөг, Silver/Hex Code #RRGGBB /#C0C0C0/ Decimal Code R,G,B /192,192,192/

В хавсралт (норматив)


Аж ахуйн нэгж байгууллагын хаягийн самбарын жишээ загвар




В.1-р зураг- Аж ахуйн нэгж байгууллагын хаягийн самбарын жишээ загвар



В.2-р зураг- Аж ахуйн нэгж байгууллагын дотор хаягийн самбарын жишээ загвар




В.3-р зураг- Байшингийн дотор хаалганы хаягийн тэмдгийн загвар



В.4-р зураг- Хаалганы хаягийн тэмдгийн байршлын жишээ загвар




В.4-р зураг-Төрийн байгууллагын нэрийн тэмдгийн бичвэр



В.5-р зураг. Материалын зураг



В.6-р зураг-Төрийн байгууллагын нэрийн тэмдгийн байршлын жишээ загвар



В.7-р зураг-Төрийн байгууллагын нэрийн тэмдгийн байршлын жишээ загвар




Тогтоож дэхлэх хэсэг

В.8-р зураг- Самбарыг тогтоох хэсэг

1



2




В.9-р зураг- Барилга, байшингийн хаягийн тэмдгийн байршлын жишээ загвар

С хавсралт (норматив)

Хаягийн самбар

С.1-р хүснэгт – Хаягийн зурган самбарын жишээ загвар

Хэмжээ мм-ээр

1 Засаг захиргааны нэгжийн хаягийн зурган самбар /Бичвэр, бүтэц, тайлбар, түлхүүр үгсийн байрлал/ ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ -Архангай	
2 Хороолол, хотхоны хаягийн зурган самбарын хэмжээ /Бичвэр, бүтэц, тайлбар, түлхүүр үгсийн байрлал/ ᠪᠠᠶ᠋ᠠᠨ ᠮᠣᠩᠭ᠋ᠣᠯ ᠬᠣᠷᠣᠣᠯᠣᠯ - Баян Монгол хороолол	
3 Талбайн хаягийн зургийн самбарын хэмжээ /Бичвэр, бүтэц, тайлбар, түлхүүр ᠶᠡᠨ ᠡᠭᠡᠨ ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠲᠠᠯᠪᠠᠢ - Их эзэн чингис хааны талбай	

4 Түүх соёлын дурсгалт газрын хаягийн зургийн самбарын хэмжээ

Богд хааны ордон музей

- Богд хааны ордон музей



С.2-р хүснэгт Объектын байрлал заасан хаягийн тэмдгийн жишээ

Хэмжээ мм-ээр

1 Объектын байрлалыг заасан тэмдгийн хэмжээ

Түлхүүр үг:
35 км – хүрэх зай
Тэрэлж – Байгалийн цогцолборт газар
Багануур – дүүрэг

Тэрэлж

- Тэрэлж

Багануур

- Багануур



2 Объектын байрлалыг заасан тэмдгийн хэмжээ

Түлхүүр үг:
15 км – хүрэх зай
Харзтай- тухайн газрын нэр

Харзтай


- Харзтай



**3 Газар, ус, түүх соёлын
дурсгалт газрын хаягийн
тэмдгийн хэмжээ**

Түлхүүр үг:

Мэлхий хад – Байгалийн цогцолборт
газар



- Мэлхий хад



Ном зүй

1. Монгол Улсын хаягжуулалтын тухай хууль.
2. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 тоот тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”.
3. Монгол Улсын газар зүйн нэрийн толь.
4. Автозамын сүлжээний зураг.